

Сурагч (60 мин)

1. Соёл судлалын үүднээс аль нь оновчтой хэллэг вэ?
 - a. Бүх соёл өөрийн өвөрмөц агуулга, үнэт зүйлсийнхээ үүднээс тэгш үнэлэгдэх, оршин тогтнох эрхтэй.
 - b. Соёлын өөрчлөлтийг гаднын жишиг, стандарттай нийцүүлэх нь соёлын хөгжлийн зайлшгүй алхам мөн.
 - c. Соёлыг "хоцрогдсон" гэж үзвэл түүнийг гадны нөлөөнд тулгуурлан өөрчлөх хэрэгтэй.
 - d. Бүгд оновчтой хэллэг
2. Бусдын соёлын амьдрал, үнэт зүйлсийг өөрийнхөөс илт давуу гэж үзэн хүлээн зөвшөөрөх үзэгдэл нь соёлын харилцан үйлчлэлийн аль хэлбэрт хамаарах вэ?
 - a. Харийн соёлын ноёрхол
 - b. Соёлын тулгалт
 - c. Соёлын хямрал
 - d. Соёлыг хуулбарлан дүүрайх
3. нь үндэстэн, угсаатны оюун санаа, өнгөрсөн үеийн түршлага, уламжлал, аж төрөх арга ухаан, утга бэлгэдлийг агуулсан, цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийн дунд ач холбогдлоо хадгалсаар ирсэн үнэт зүйлс мөн.
 - a. соёлын үнэт зүйл
 - b. соёлын өв
 - c. соёлын үнэлэмж
 - d. соёлын орон зай
4. Соёлын үзэгдлүүд тэмдгэн хэлбэрээр оршдог. Тэмдгийн хамгийн түгээмэл хэлбэрийг нэрлэ
 - a. соёл
 - b. Үнэлэмж
 - c. үрлаг
 - d. хэл
5. Нийгмийн амьдралд соёлын гүйцэтгэдэг чиг үүргүүдийг жагсаахдаа буруу зүйл дүрдсэн нь аль вэ?
 - a. танин мэдэхүйн чиг үүрэг
 - b. мэдээллийн чиг үүрэг
 - c. шашны чиг үүрэг
 - d. хэм хэмжээний чиг үүрэг
6. Аль ёс суртахууны чиг үүрэгт үл хамаарах вэ?
 - a. Хүмүүсийн хүсэл сонирхлыг нэгтгэх
 - b. Хүмүүс үйлдэл, үйл ажиллагаагаа хянаж удирдах
 - c. Бие хүний зан төлөвийг зохицуулах
 - d. Ёс суртахууны нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар мэдэх
7. Хиймэл оюун ухааныг ашиглахад ёс зүйн хувьд ямар үйлдэл нь буруутгагдах вэ?
 - a. Судалгааны санаа авах
 - b. Даалгавраа AI-гаар хийлгээд өөрийн нэрээр өгөх
 - c. Зөвшөөрөлтэй мэдээлэл ашиглах
 - d. Бүгд
8. Хувийн ашиг сонирголоо бусдаас дээгүүр тавьж, зорилгодоо хүрэхийн тулд тэдний эрх ашгийг үл хүндлэх үзлийг ёс зүйд юу гэдэг вэ?
 - a. Хувийн үзэл
 - b. Амин хувиа хичээх үзэл
 - c. Хувь хүн төвт үзэл
 - d. Гаж үзэл
9. Ёс суртахууны нээлттэй асуудал гэж юу вэ?
 - a. орчин үед даяаршлын үйл явцтай холбоотой нийгэмд тулгамдаж буй асуудлууд
 - b. нээлттэй нийгмийн асуудлууд
 - c. ёс суртахууны хэм хэмжээгээр төгс шийдвэрлэж болдоггүй асуудлууд
 - d. Бүгд
10. Оюуны соёлын жишээ бүхий мөрийг олно уу

1	Тунгалаг тамир роман	"Монголын нэг өдөр" зураг	шинжлэх ухаан	гар утас
2	соёлын биет өв	соёлын биет бус өв	соёлын өв	соёлын үнэт зүйлс
3	зүйр үг	уртын дуу	сансрын хөлөг	дууны цомог

4	монгол ардын үлгэр	малгай, бүсээ дээдлэх ёс	үгийн хорио цээр	тамганы бэлгэдэл
---	-----------------------	--------------------------	---------------------	------------------

- a.1 b.2 c.3 d.4
11. Соёлыг материаллаг болон биет бус гэж хуваахдаа ямар шалгуурыг үндэс болгодог вэ?
a. Соёлын хэрэглээний зорилго b. Соёлын хэлбэр, илрэх байдал
c. Соёлын түвшин d. Нийгмийн хөгжлийн үе шат
12. Дараах тайлбаруудаас аль нь соёлын даяаршлыг бүрүү ойлгосон жишээ вэ?
a. Солонгос дуу, кино олон оронд түгэн дэлгэрч байна
b. Интернэтээр дамжин өөр өөр соёлын хэв маяг түгж байна
c. Соёлын даяаршлын үр дүнд бүх улс нэг хэл, нэг соёлтой болж байна.
d. Түргэн хоол, хувцасны хэв маяг улс орнуудад тархаж байна
13. Иргэн хууль зүйн мэдлэггүйгээсээ болж зөрчил гаргасан тохиолдолд ямар үр дагавар үүсэх вэ?
a. хуульд заасан хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.
b. энэ асуудлыг шүүгч эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэнэ.
c. хуульд заасан хариуцлагыг хөнгөрүүлнэ.
d. Хуульд заасан хариуцлагыг хүндрүүлнэ.
14. Аль нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэр вэ?
a. Дүгнэлт b. Тогтоол c. Магадлал d. Дээрх бүгд
15. Яамны сайд Үндсэн хууль зөрчиж шийдвэр гаргасан асуудлыг хянах эрх бүхий субъект аль нь вэ?
a. Үндсэн хуулийн цэц b. Захиргааны хэргийн шүүх
c. Улсын их хурал d. Төрийн албаны салбар зөвлөл
16. Иргэн А замын хөдөлгөөний журам зөрчсөн тул түүнд цагдаа торгох шийтгэл оногдуулжээ. Цагдаа эрх зүйн хэм хэмжээг
a. Сахисан b. хэрэглэсэн
c. ашигласан d. зөрчсөн
17. А компани цас цэвэрлэх машин үйлдвэрлэсэн байна. Тухайн барааны ашиглалтын дуусах хугацааг бүтээгдэхүүний танилцуулга дээр тодорхой заагаагүй байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд зааснаар А компани хэдэн жилийн хугацаанд үйлдвэрлэсэн барааны сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүрэг хүлээх вэ?
a. Хуульд энэ талаар нарийвчлан зохицуулаагүй
b. Хуульд ашиглалтын дуусах хугацааг заавал тэмдэглэнэ гэж заасан
c. 5 хүртэл жилийн хугацаанд үйлдвэрлэсэн барааны сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүрэг хүлээнэ
d. 10 хүртэл жил хугацаанд үйлдвэрлэсэн барааны сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүрэг хүлээнэ
18. Иргэн Б оёдлын машин 20 сая төгрөгөөр худалдан авчээ. Гэтэл 1 сарын дараа тус машинд эвдрэл гарчээ. Энэ талаар худалдагчид хэлсэн боловч барааны доголдыг арилгах хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3 сар хэтрүүлсэн байна. Иргэн Б хуулийн дагуу ямар шаардлага гаргах эрхтэй вэ?
a. Энэ талаар хуульд тодорхой зохицуулалт тусгагдаагүй
b. Хугацаа хэтэрсэн хоног тутам бараа, ажил, үйлчилгээний үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алданги шаардах эрхтэй
c. Цагдаагийн байгууллагад хандах эрхтэй
d. Доголдлыг арилгах хугацааг хойшлуулахаар талууд тохиролцох эрхтэй
19. Эх газрын эрх зүйн бүлийн онцлог шинжид аль нь хамаарахгүй вэ?
a. Нарийн системчлэл бүхий хэм хэмжээний тогтолцоотой байдаг
b. Онцгой тохиолдолд шүүхийн жишиг хэрэглэдэг



- с. Эрх зүйгээ нийтийн болон хувийн эрх зүй гэж төрөлжүүлэн ангилдаг
 д. Үндсэн эрх зүйн эх сурвалж нь хууль, хуульчилсан акт, олон улсын гэрээ, зан заншлын хэм хэмжээ гэм мэт эрх зүйн актууд байдаг
20. Аль бодомж зөв вэ?
 а. Эрх зүйн зөрчлийг санаатайгаар, бас болгоомжгүйгээр үйлддэг
 б. Эрх зүйн зөрчлийг зөвхөн санаатайгаар үйлддэг
 с. Эрх зүйн зөрчлийг болгоомжгүйгээр үйлддэг.
 д. Бүгд зөв
21. Ажилтан А-д ажилдаа хариуцлагагүй хандсан гэх үндэслэлээр албан тушаал бууруулах шийтгэл оногдуулжээ. Энэ нь хууль зүйн хариуцлагын аль төрөлд хамаарах вэ?
 а. Торгууль
 б. Иргэний эрх зүйн эд хөрөнгийн хариуцлага
 с. Захиргааны хариуцлага
 д. Сахилгын шийтгэл
22. Бүлгийн шинжийг нэрлэхдээ илүүц зүйл дүрдсаныг олно уу.
 а. Хүйс, арьс өнгө, нийгмийн байдал зэргээр адил байх
 б. Бусад хүмүүс тухайн бүлгийн гишүүн гэдэг үүднээс ханддаг байх
 с. Гишүүд нийтээр дагадаг хэм хэмжээ бүхий байх
 д. Өөрийгөө тухайн бүлэгт харьяалуулах адилсал бүхий байх
23. Бүгд найрамдах төр бүхий нийгэм нь аль хэв маягт хамаарах вэ?
 а. Орчин үеийн нийгэм
 б. Аж үйлдвэржилтийн өмнөх нийгэм
 с. Постмодерн нийгэм
 д. Уламжлалт нийгэм
24. Зорилтот түүврээс санамсаргүй түүврийн ялгагдах гол ялгаа юу вэ?
 а. Бүх нэгжээс тааралдсаныг нь сонгох
 б. Бүх нэгжид судалгаанд оролцох боломжийг тэгш олгон сонгох
 с. Тодорхой онцлог нэгжийг сонгох
 д. Тодорхой нийтлэг шинжийг илтгэх нэгжийг сонгох
25. Аль хувьсагч нь тасалдалттай буюу дискрет байна вэ?
 а. Нас
 б. Биеийн өндөр
 с. Жин
 д. Ажилчдын тоо
26. Нийгмийн харилцан үйлдэл нь
 а. Нийгмийн микро түвшний ойлголт
 б. Нийгмийн макро түвшний ойлголт
 с. Нийгмийн мезо түвшний ойлголт
 д. Нийгмийн ухааны ойлголт биш.
27. Нийгмийн институт гэж юу вэ?
 а. Нэгдмэл зорилгын төлөө үйл ажиллагаа явуулж буй байгууллага
 б. Хэрэгцээг хангахын төлөөх байр суурь, үүргүүд
 с. Ижил төстэй хүмүүсийн нэгдэл
 д. Байгууллагуудын нэгдэл
28. Э.Дюркгеймийн үзсэнээр нэг нийгэм нөгөөгөөр солигдох үед хүмүүс өөрсдийн үйлдлийн үнэт зүйлсийн баримжаагаа лдаж, хэм хэмжээ зохицуулалтгүй байх нийгмийн төлөв байдлыг юу гэдэг вэ?
 а. Хямралт төлөв байдал
 б. Аномийн төлөв байдал
 с. Девиацийн төлөв байдал
 д. Шилжилтийн төлөв байдал
29. Хүмүүсийн өдөр тутмын амьдрал тэр чигээрээ бэлгэдэл бүхий бүхий бөгөөд өөр хоорондоо бэлгэ тэмдгийн утгыг ойлголцох замаар харилцаж байдаг гэж аль онол үздэг вэ?
 а. Солилцооны онол
 б. Символик интеракционизм
 с. Фрейдизм
 д. Феноменологи
30. Нийгмийн гажуудал нь
 а. Тэгш бус байдалтай холбоогүй
 б. Нийгмийн бүхий л давхраануудад гаж гэгдэх зүйлс ижил утгатай байна
 с. Гаж, буруу гэх үнэлгээ нь ангийн хуваагдлын илрэл
 д. Ноёрхогч ангийн эрх ашиг, үзэл сурталд үл тохирох зүйлс бол гаж



31. Бүтэц үүргийн онолын хувьд нийгмийн давхраажилтын аль хэмжигдэхүүнийг сүүр шалтгаан гэж үздэг вэ?
- Ажил мэргэжлийн нэр хүнд
 - Эрх мэдэл
 - Эдийн засаг
 - Бүгд зөв
32. Аль онол нь ядууралд өртөхийг хувийн хүчин зүйлстэй холбон тайлбарладаг вэ?
- Марксизм
 - Бүтцийн хандлага
 - Дарвинизм
 - Соёлын хандлага
33. Улс төрийн итгэл үнэмшилтэй ижил төсөөтэй ойлголтыг олно уу.
- Улс төрийн ухамсар
 - Улс төрийн мэдлэг
 - Улс төрийн соёл
 - Бүгд зөв.
34. Хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг улс төрийн тогтолцоо аль нь вэ?
- Авторитар
 - Тоталитар
 - Ардчилсан
 - Аристократ
35. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчим нь сонгогч саналаа нууцаар гаргахад хамаарах уу?
- Сонгогч саналаа нууцаар гаргах ёстой тул сонгууль зохион байгуулах үйл явц ил тод байх ёсгүй
 - Сонгууль зохион байгуулах үйл явцын ил тод байдлыг хангах нь сонгогч саналаа нууцаар гаргах зарчимтай холбоогүй
 - Сонгуулийн ямар мэдээлэл вэ гэдгээс шалтгаална.
 - сонгууль зохион байгуулах үйл явцын ил тод байдал хийгээд сонгогч саналаа нууцаар гаргах зарчим нь өөр хоорондоо зөрчилтэй
36. Дараах сонголтуудаас ардчиллын ач тус, үнэ цэнийг оновчтой илэрхийлсэн байна вэ ?
- Ардчилсан улсад иргэдийн улс төрд оролцох идэвх, сонирхол өндөртэй.
 - Ардчилсан улсад улс төрийн хариуцлагад онцгой анхаарч ажилладаг.
 - Ардчилсан улсад иргэдийн оролцоо, тэгш эрх, шударга сонгууль, хүний эрх, олон намын тогтолцоо, хуульд захирагдах ёсыг тогтоодог.
 - Ардчилсан улсад төлөөлөгчид нь иргэдийн санал бодлыг тэр болгон бүрэн илэрхийлж чаддаггүй.
37. Монгол улсын Ерөнхийлөгчийн түр эзгүйд бүрэн эрхийг нь хэн хэрэгжүүлэх вэ?
- Ерөнхий сайд
 - Олонхын суудалтай улс төрийн намын дарга
 - Үндсэн хуулийн цэцийн дарга
 - УИХ-ын дарга
38. С.Хантингтоны үзэл баримтлал ёсоор орчин үеийн мөргөлдөөний гол хэлбэр аль нь вэ?
- Соёл иргэншлийн мөргөлдөөн
 - Их гүрнүүдийн мөргөлдөөн
 - Үзэл суртлын тэмцэл
 - Угсаатны бүлэгүүдийн тэмцэл
39. Улс төрийн лобби хэмээх ойлголт ямар утгыг илэрхийлдэг вэ?
- Шахалт үзүүлэх
 - Нууцаар удирдах
 - Авлига өгөх
 - Дарамтлах
40. УИХ-аас “Иргэн төрийн албанд анх ороход тавих ёс зүйн шаардлагыг өндөрсгөх, ёс зүйн зөрчил гаргаж байсан хүнийг төрийн жинхэнэ албанд томилохгүй, албан тушаал дэвшүүлэхгүй байх зарчмыг хатуу мөрдөх” гэсэн тогтоол гаргажээ. Энэ нь мөн.
- Шаардлага
 - Дэмжлэг
 - Шийдвэр
 - Эргэх холбоо
41. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд тусгаснаар Ази, Номхон далайн бүс нутагт ямар бодлого баримталж ажилладаг вэ?
- Олон талт хамтын ажиллагаанд оролцох
 - Хоёр талын найрсаг харилцаа
 - Стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх
 - Аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэх
42. Олон улсын харилцааны улс оролцогчдын нэг Бага улсын үндсэн гол шинжид үл хамаарах нь аль нь вэ?
- Түүхий эдийн худалдаа, хөрөнгө оруулалт, зээл тусламжаас ихээхэн хамааралтай
 - Хөрш улс, бүс нутагтаа жинтэй нөлөө үзүүлж чаддаг



- с. Өөрийгөө хамгаалах хангалтай цэрэг зэвсэгт хүчингүй
 д. Олон улсын харилцаанд оролцох улс төрийн жин багатай
43. Дараах субъектээс аль нь улс биш оролцогчид багтахгүй вэ?
 а. Үндэстэн дамнасан корпораци
 б. Засгийн газар
 с. Олон улсын төрийн бүс байгууллага
 д. Шашны бүлэглэл
44. Монгол Улсын хамтын нийгэмлэгийн байгууллага дахь оролцооны үндсэн зарчмуудын нэг болох олон түлгүүрт байх зарчмын гол утгыг аль нь оновчтой илэрхийлсэн байна вэ?
 а. Олон улс оронтой хамтран ажиллах, гадаад харилцааг олон хэлбэрээр явуулах
 б. Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах
 с. Үндэсний язгуур ашиг сонирхлыг сахин хамгаалсан, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх
 д. Стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн Монгол Улс дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэгцвэржүүлэх

45. Зөв хослуулна уу?

1. ОУХ-нд оролцох үүрэг нь :	А. ОУХ-нд улс төр, эрх зүй, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн гэсэн үйл ажиллагаагаар оролцдог.
2. ОУХ-нд оролцох үйл ажиллагааны чиглэл нь:	Б. МУ бусад улсын улс төр, эдийн засаг, соёлын хүч чадавх, үйл ажиллагааг өөрийн боломжоор хянах, үнэлэх
3. ОУХ-нд оролцох нөлөө нь :	В. Олон улсын улс төр, эрх зүй, эдийн засаг, соёлын зэрэг олон талт харилцаанд гадаад бодлогоороо дамжуулан оролцох үйл ажиллагааны цар хүрээ, нөлөөллөөр тодорхойлогдоно.

- а. 1а2б3в б. 1в2а3б с. 1с2б3в д. 1б2а3в
46. Хувь хүний орлогын бууралтын үр дүнд тодорхой барааны эрэлт буурсан. Тиймээс энэ бараа нь:
 а. өндөр чанартай бараа б. зайлшгүй хэрэгцээтэй бараа
 с. тансаг хэрэглээний бараа д. чанар муутай бараа
47. Хэрэв таны нэрлэсэн цалин 400000-аас 450000 төгрөг болж өссөн. Таны худалдаж авдаг бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ нь дунджаар 10%-иар өссөн бол:
 а. таны бодит цалин нэмэгдсэн б. таны бодит цалин буурсан;
 с. таны бодит цалин өөрчлөгдөөгүй хэвээр үлдсэн д. таны нэрлэсэн цалин буурсан
48. Нэрлэсэн ДНБ 2000 онд 1500 тэрбум төгрөг байсан. 2001 онд 1650 тэрбум төгрөг болж, үнийн түвшин мөн хугацаанд 5%-иар өссөн бол 2000 оныг суурь он гэж үзвэл бодит ДНБ хэрхэн өөрчлөгдсөн бэ?
 а. Бодит ДНБ 20 тэрбум төгрөгөөр буурсан
 б. Бодит ДНБ 65 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн
 с. Бодит ДНБ 71 тэрбум төгрөгөөс дээш өссөн
 д. Бодит ДНБ өөрчлөгдөөгүй хэвээр байна
49. Дараах ажил хийдэггүй хүмүүсээс аль нь «ажилгүй хүн» гэсэн бүлэгт хамаарахгүй вэ?
 а. хөдөлмөрийн чадвараа алдсан хүн б. ял эдэлж байгаа хүн с. ажил хайгаагүй хүн
 д. 16 нас хүрээгүй хүн е. Дээрх бүх хүн.
50. Боломжит ДНБ нь мөн.
 а. тухайн онд эдийн засагт үйлдвэрлэсэн бүх бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг
 б. эдийн засгийн үйл ажиллагааны дээд хэмжээгээр эдийн засагт үйлдвэрлэж болох бүх бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг
 с. эдийн засаг нөөцийг бүрэн ашигласан тохиолдолд үйлдвэрлэж болох эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг
 д. хөрөнгө оруулалтын дээд түвшин дэх ДНБ-ний хэмжээ



Хариу

1	2	3	4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27	28	29	30
31	32	33	34	35	36	37	38	39	40
41	42	43	44	45	46	47	48	49	50

